



2114

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 1/314

Булган

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3./н/, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.2.1, Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчныг хамгаалах, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: О.Гантулга - Аймгийн Засаг даргын орлогч

- Гишүүд: - Д.Буманбаяр - Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Б.Одхүү - Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
- А.Гантөмөр - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- З.Гомбо - Цагдаагийн газрын дарга
- С.Батболд - Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Ү.Бямбасүрэн - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
- Бүх сумын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: С.Алтанзул - Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Аймгийн хэмжээнд бичил уурхай эрхлэгч болон нөхөн сэргээлт хийж байгаа аж ахуй нэгж, нөхөрлөлийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийж, үр дүнг 2018 оны 06 дугаар сарын 15-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /О.Гантулга/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  З БАТЗОРИГ

